



**“НАЛАЙХЫН ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК” ХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН ТУШААЛ**

2025 оны 06 сарын 18 өдөр

Дугаар А/25

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.1 дэх хэсэг, Налайхын үйлдвэрлэл, технологийн парк хаалттай хувьцаат компанийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.6.14 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн удирдах ажилтнуудын 2025 оны 06 сарын 09-ний өдрийн шуурхай зөвлөгөөнд Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогчоос өгсөн үүрэг даалгаврын дагуу байгууллагын барилга байгууламж, эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалтад хяналт тавьж, ажлын байран дахь хөдөлмөрийн аюулгүй байдал, осол аюулаас урьдчилан сэргийлэх бэлтгэл, бэлэн байдлын үзлэгийг зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

О.Чулуун-Эрдэнэ (Гадаад харилцаа хамтын ажиллагаа хариуцсан мэргэжилтэн)

Гишүүд: Б.Болортуяа (Хуулийн мэргэжилтэн)

Н.Пүрэвсүрэн (Ахлах мэргэжилтэн)

2. Үзлэгийг 2025 оны 6 дугаар сарын 18-ны өдөр зохион байгуулж, ажлын тайланг 2025 оны 06 дугаар сарын 19-ний өдрийн дотор Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг Ажлын хэсгийн ахлагч (О.Чулуун-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ч.РАДНААБАЗАР